

ВҮС ХХК

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЛТАНШИРЭЭ
СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ “ЗАЛАА
ТОЛГОЙ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар. 2026

АГУУЛГА

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2. Төслийн хүчин чадал	3
БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
2.1. Төсөл хэрэгжих талбайн байршил.....	5
2.2. Физик газарзүйн нөхцөл.....	6
2.3. Төслийн талбайн газрын гадарга, Онцлог	6
2.4. Уур амьсгалын ерөнхий шинж, онцлог	6
2.5. Төслийн талбайн агаарын чанар	7
2.6. Усан орчин	8
2.7. Хөрсөн бүрхэвч	9
2.8. Хөрсний хими, физикийн үндсэн үзүүлэлт	10
2.9. Ургамлан нөмрөг	10
2.10. Амьтны аймаг	12
2.11. Тусгай хамгаалалттай газар нутаг	14
2.12. Нийгэм эдийн засгийн үзүүлэлт	15
БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	17
3.1. Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл	17
3.2. Агаарын чанарт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	17
3.3. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл	17
3.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	17
3.5. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл.....	17
3.6. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	18
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
3.7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	20
3.8. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө.....	23
3.9. Түүх, соёлыг өвийг хамгаалах төлөвлөгөө	23
3.10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	24
3.11. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	25
3.12. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	26
3.13. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний төлөвлөгөө.....	27
3.14. БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	28
3.15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	29

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	3
Хүснэгт 2. Уурхай бүрд хамаарах хөрс, хүдрийн хэмжээ	3
Хүснэгт 3. Ил уурхайн хайлуур жоншны хүдэр олборлолтын календарьчилсан төлөвлөлт	3
Хүснэгт 4. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол.....	5
Хүснэгт 5. Хөрсний химийн үндсэн шинжийн үзүүлэлтүүд.....	10
Хүснэгт 6. Хөрсний механик бүрэлдэхүүн	10
Хүснэгт 7. Ургамлын бүлгэмдэл.....	12
Хүснэгт 8. Амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүн (2019, 2025 оны судалгаа).....	13
Хүснэгт 9. Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл.....	16
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалын дүн.....	19
Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	20
Хүснэгт 12. Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.....	24
Хүснэгт 13. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 14. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	26
Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	27
Хүснэгт 16. БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	28
Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг.....	5
Зураг 2. Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй PM2.5-ын хоногийн дундаж агууламж, тархалт	7
Зураг 3. Овоолгоос үүсэх PM2.5-ын хоногийн дундаж агууламж, тархалт.....	8
Зураг 4. Овоолгоос үүсэх PM2.5-ын хоногийн дундаж агууламж, тархалт.....	8
Зураг 5. Төсөл хэрэгжих талбай орчмын хөрсөн бүрхэвчийн хэв шинж	9
Зураг 6. Монгол орны ургамал-газар зүйн мужлал.....	11
Зураг 7. Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчмын ургамлан бүрхэвчийн бүлгэмдэл	11
Зураг 8. Монгол орны зоогеографийн мужлал (А.Г.Банниковынхоор).....	13
Зураг 9. Төслийн талбайн ойр байрлах улсын тусгай хамгаалалттай газар.....	15

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр - “Залаа толгой” хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төсөл

Төслийн байршил - Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 450 км, Дорноговь аймгийн төв Сайншанд хотоос зүүн хойш 90 км, төмөр замын 31-р зөрлөгөөс зүүн тийш 70 км, Алтанширээ сумын төвөөс зүүн хойд зүгт 20 орчим км зайд оридог.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Улсын бүртгэлийн дугаар	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг
1	“БҮС” ХХК	9019041013	MV-021729	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, бага тойруу, 11, 33 тоот Утас:9666-2866

1.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Ил уурхайн эцсийн хүрээнд хамаарах хайлуур жоншны хүдрийн хэмжээ 50.8 мян.тн бөгөөд ил уурхайн олборлолтын жилийн хүчин чадлыг 50.8 мян.тн хайлуур жоншны хүдэр байх ба ашиглалтын хугацааг 1 жилд 9 сарын хугацаанд олборлохоор тооцож олборлолтын төлөвлөгөөг улирлаар төлөвлөсөн.

Ил уурхайн хүрээн дэх ашиглалтын нөөцийн хэмжээ

Ил уурхайгаар олборлох хайлуур жоншны хүдрийн хэмжээ нийт 50.8 мян.тн, хөрс хуулалтын хэмжээ нийт 178.600 мян.м³, хөрс хуулалтын дундаж коэффициент 3.51 м³/тн тус тус байна.

Хүснэгт 2. Уурхай бүрд хамаарах хөрс, хүдрийн хэмжээ

Уурхай	Хөрс хуулалт, м ³	Хайлуур жоншны хүдэр, тн	СаF ₂ -ийн агуулга, %	Хөрс хуулалтын дундаж коэффициент, м ³ /тн	Хайлуур жоншны нөөц, тн
1-р уурхай	169,993	48,137	23.62	3.53	11,370
2-р уурхай	8,607	2,703	23.50	3.18	635.1
Нийт	178,600	50,840	23.61	3.51	12,005.2

Ил уурхайн хайлуур жоншны хүдэр олборлолтын төлөвлөлт

Хүснэгт 3. Ил уурхайн хайлуур жоншны хүдэр олборлолтын календарьчилсан төлөвлөлт

Үзүүлэлт	Нэгж	Ашиглалтын жил			Нийт
		1-р улирал	2-р улирал	3-р улирал	
Уурхай-1					
Жоншны хүдэр олборлолт	тн	13,479.8	15,917.0	18,740.3	48,137.0
Дундаж агуулга, СаF ₂	%	23.62	23.62	23.62	23.62
Хайлуур жоншны нөөц	тн	3,183.9	3,759.6	4,426.5	11,370.0
Хөрс хуулалт	м ³	63,488.6	68,658.3	37,846.2	169,993.0
Хөрс хуулалтын коэффициент	м ³ /тн	4.71	4.31	2.02	3.53
Нийт уулын цул	м ³	68,481.1	74,553.4	44,787.0	187,821.5
Уурхай-2					
Жоншны хүдэр олборлолт	тн	2,703.0			2,703.0
Дундаж агуулга, СаF ₂	%	23.50			23.50
Хайлуур жоншны нөөц	тн	635.1			635.1

ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЛТАНШИРЭЭ СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ “ЗАЛАА ТОЛГОЙ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрс хуулалт	м ³	8,607.0			8,607.0
Хөрс хуулалтын коэффициент	м ³ /тн	3.18			3.18
Нийт уулын цул	м ³	9,608.1			9,608.1
Нийт ил уурхайн жоншны хүдэр олборлолтын календарьчилсан төлөвлөлт					
Жоншны хүдэр олборлолт	тн	16,182.8	15,917.0	18,740.3	50,840.0
Дундаж агуулга, СаF ₂	%	23.60	23.62	23.62	23.61
Хайлуур жоншны нөөц	тн	3,819.1	3,759.6	4,426.5	12,005.2
Хөрс хуулалт	м ³	72,095.6	68,658.3	37,846.2	178,600.0
Хөрс хуулалтын коэффициент	м ³ /тн	4.46	4.31	2.02	3.51
Нийт уулын цул	м ³	78,089.2	74,553.4	44,787.0	197,429.6
Үйлдвэрлэлийн нөөц					
Уурхай-1					
Жоншны хүдэр олборлолт	тн	13,479.8	15,917.0	18,740.3	48,137.0
Дундаж агуулга, СаF ₂	%	23.62	23.62	23.62	23.62
Хайлуур жоншны нөөц	тн	3,183.9	3,759.6	4,426.5	11,370.0
Хаягдлын хувь	%	2.87	2.87	2.87	2.87
Хаягдах жоншны хүдрийн хэмжээ	тн	386.5	456.4	537.3	1,380.2
Хаягдах хайлуур жоншны хэмжээ	тн	91.3	107.8	126.9	326.0
Бохирдлын хувь	%	4.30	4.30	4.30	4.30
Бохирдлын хэмжээ	тн	563.1	664.9	782.9	2,010.9
Үйлдвэрлэлийн нөөц дэх жоншны хүдрийн хэмжээ	тн	13,656.4	16,125.5	18,985.9	48,767.7
Дундаж агуулга, СаF ₂	%	22.65	22.65	22.65	22.65
Үйлдвэрлэлийн нөөц дэх хайлуур жоншны нөөц	тн	3,092.7	3,651.8	4,299.6	11,044.0
Уурхай-2					
Жоншны хүдэр олборлолт	тн	2,703.0			2,703.0
Дундаж агуулга, СаF ₂	%	23.50			23.5
Хайлуур жоншны нөөц	тн	635.1			635.1
Хаягдлын хувь	%	2.87			2.9
Хаягдах жоншны хүдрийн хэмжээ	тн	77.5			77.5
Хаягдах хайлуур жоншны хэмжээ	тн	18.2			18.2
Бохирдлын хувь	%	5.38			5.38
Бохирдлын хэмжээ	тн	71.1			71.1
Үйлдвэрлэлийн нөөц дэх жоншны хүдрийн хэмжээ	тн	2,696.6			2,696.6
Дундаж агуулга, СаF ₂	%	22.9			22.9
Үйлдвэрлэлийн нөөц дэх хайлуур жоншны нөөц	тн	616.9			616.9
Нийт					
Жоншны хүдэр олборлолт	тн	16,182.8	15,917.0	18,740.3	50,840.0
Дундаж агуулга, СаF ₂	%	23.6	23.6	23.6	23.6
Хайлуур жоншны нөөц	тн	3,819.1	3,759.6	4,426.5	12,005.2
Хаягдлын хувь	%	2.87	2.87	2.87	2.87
Хаягдах жоншны хүдрийн хэмжээ	тн	464.0	456.8	537.8	1,458.7
Хаягдах хайлуур жоншны хэмжээ	тн	109.5	107.9	127.0	344.4
Бохирдлын хувь	%	4.48	4.30	4.30	4.30
Бохирдлын хэмжээ	тн	704.8	664.9	782.9	2,152.6
Үйлдвэрлэлийн нөөц дэх жоншны хүдрийн хэмжээ	тн	16,423.6	16,125.0	18,985.3	51,534
Дундаж агуулга, СаF ₂	%	22.59	22.65	22.65	22.63
Үйлдвэрлэлийн нөөц дэх хайлуур жоншны нөөц	тн	3,709.6	3,651.7	4,299.5	11,661

БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ


2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ

“Залаа толгой” хайлуур жоншны орд (MV-021729) нь Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 450 км, Дорноговь аймгийн төв Сайншанд хотоос зүүн хойш 90 км, төмөр замын 31-р зөрлөгөөс зүүн тийш 70 км, Алтанширээ сумын төвөөс зүүн хойд зүгт 20 орчим км зайд оршдог. Орд газар нь газар зүйн дараах солбицлуудаар хязгаарлагдана. Доорх хүснэгтэд уурхайн солбицлын цэгийг тэмдэглэв.

Хүснэгт 4. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1	110° 44' 41.92"	45° 40' 1.62"
2	110° 34' 1.93"	45° 40' 1.62"
3	110° 34' 1.92"	45° 37' 50.8"
4	110° 36' 50.51"	45° 37' 50.8"
5	110° 36' 50.51"	45° 37' 6.27"
6	110° 39' 0"	45° 37' 6.27"
7	110° 39' 0"	45° 37' 50.8"
8	110° 44' 0"	45° 37' 50.8"
9	110° 44' 0"	45° 33' 1.61"
10	110° 43' 49.29"	45° 33' 1.61"
11	110° 43' 49.29"	45° 32' 4"
12	110° 37' 54.82"	45° 32' 4"
13	110° 37' 54.82"	45° 31' 20"
14	110° 37' 3"	45° 31' 20"
15	110° 37' 3"	45° 30' 1.62"
16	110° 44' 41.89"	45° 30' 1.63"

Зураг 1. Төслийн талбайн байршилын зураг



2.2. ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

Алтанширээ сум нь 734.8 м² газар нутагтай бөгөөд баруун урд талаараа Сайншанд, Сайхандулаан сум, баруун талаараа Айраг сум, хойд талаараа Иххэт сум болон Хэнтий аймгийн Галшар сум, зүүн-зүүн урд талаараа Дэлгэрэх, Өргөн сумуудтай хил залгаа оршино.

Талбай нь газар зүйн хувьд Дорноговь аймгийн нутгийг бүхэлд нь хамрах говийн их мужид хамаарна. Гадаргуугийн хувьд тусгай зөвшөөрлийн талбайн ихэнх хэсэгт 800-1000 метрийн үнэмлэхүй өндөржилт бүхий эрчимтэй, хэрчигдэлтэнд орсон 150-550 метрийн харьцангуй өндөртэй дунд зэргийн уулархаг гадаргуу хөгжсөн.

Талбайн хэмжээнд говийн бор хөрс түгээмэл тархалттай байдаг ба энэ хөрс нь харьцангуй нимгэн, ялзмагийн хувьд бага байдаг тул ургамлын бүрхэвчээр сийрэг.

Хэдийгээр нам уулс зонхилох боловч харьцангуй илэрц сайтай, агаар сансрын зурагт зурагламж өндөртэй тусгагддаг. Талбайн хэмжээнд байнгын урсгалтай гол байхгүй бөгөөд харин олон тооны нуур тойром, хуурай сайр болон жижиг шанд түгээмэл тархсан байдаг. Ундны болон ахуйн хэрэглээний усыг гар худаг, цөөн тооны гүний худгаас авч ашигладаг.

2.3. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ГАЗРЫН ГАДАРГА, ОНЦЛОГ

Төсөл хэрэгжих талбай орчмын бүс нутаг нь хөрс газарзүйн мужлалын хувьд говийн хөрсний их мужийн заримдаг цөлийн бор хөрсний дэд бүсийн Дорноговийн тойрогт хамаарна /Монголын Үндэсний атлас, 2009/.

Энэ бүсэд өдлөг хялгана-боролзойт, өдлөг хялганат, өдлөг-хялгана-таана-бударганат, өдлөг хялгана-бударганат, харгана-өдлөг хялганат, тэсэг-өдлөг хялганат, хотир-өдлөг хялганат, шаваг-өдлөг хялганат, бор бударганат, бор бударгана-хойргот, баглуур болон сөөгт цөлөрхөг хээр их тохиолдоно.

Тусгай зөвшөөрлийн талбай нь байгалийн бүс бүслүүрийн хувьд цөлөрхөг хээрийн бүсэд, ургамал газар зүйн мужлалаар Евроазийн хээрийн мужийн хойт говийн цөлөрхөг хээрийн бүсийн Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтана.

Цөлөрхөг хээрт жижиг үетнүүдээс гадна гурвалсан боролзой, төлөгчдүү боролзой, таана, орог тэсэг, бор бударгана, навчгүй баглуур нохой шээрэнгэ, улаан харгана, бунгийн харгана, шивүүрт харгана, нарийн навчит цахилдаг, говийн тост, хамхуул, хамхаг, цульхир, монгол зорлог, монгол догор, данхар хависхана, шарилж, шаваг элбэг ургана.

2.4. УУР АМЬСГАЛЫН ЕРӨНХИЙ ШИНЖ, ОНЦЛОГ

Тусгай зөвшөөрлийн талбай нь Төв Азийн геоморфологийн их мужийн Дорнод дэд мужид хамаардаг, гандуу дулаан зунтай, хүйтэн өвөлтэй, хээрийн бүсэд багтана.

Уур амьсгалын гол хүчин зүйл болох агаарын температурыг авч үзвэл жилийн дундаж-0.50С, хамгийн дулаан байх VII сарын дундаж температур +190С, хамгийн хүйтэн I сард дунджаар - 21.30С байна. Хамгийн их хүйтрэлт 1969 онд тэмдэглэгдсэн ба энэ нь -21.30С байжээ.

Жилд орох хур тунадасны хэмжээ 122.7-342.6 мм хооронд хэлбэлзэх ба дунджаар 183-205 мм байна. Үүнээс хүйтний улиралд 7-12 мм, дулааны улиралд 117-332 мм байдаг. Хур тунадас гол төлөв зуны улиралд аадар бороо хэлбэрээр ордог ба энэ нь нийт хур тунадасны 85%-ийг эзэлдэг. Цасан бүрхүүлийн зузаан 7-12 см-ээс хэтрэхгүй, харин гуу жалга, хотгор хэсгүүдэд 1м хүртэл нэмэгддэг. Энэ нь хур тунадасны 15%-ийг бүрдүүлдэг.

Салхины хурд, хүчтэй салхитай өдрийн тоо зэрэг нь усны ууршилтад гол нөлөө үзүүлдэг. Хүчтэй салхи гол төлөв IV-V саруудад явагддаг. Хамгийн их хуурай, салхитай үе нь IV-V сард тохиох ба энэ үед салхины хурд 20-25 м/с хүрч шороон шуурга үүсгэдэг.


Улирлын хөдөлтийн гүн талбайн хэмжээнд 3.5 м байх ба VI сард бүрэн гэснэ. Энэ бүс нутагт мөнх цэвдэг байхгүй.

2.5. ТӨСЛИЙН ТАЛБАЙН АГААРЫН ЧАНАР


Олон улс болон дотоодын судалгаа, шинжилгээнд түгээмэл ашиглагдаж буй агаарын бохирдлын загварчлалын программ хангамжийн тусламжтай Залаа толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаа болон бус нутгийн цаг уурын үзүүлэлт, 10 км-ын радиус дахь газрын гадаргын тофографийн өгөгдөлд тулгуурлан агаарын бохирдлын тархалтын зураглалыг боловсруулсан. Сайншанд станц орчмын салхины нөхцлийн хувьд баруун хойд болон баруун урд зүгийн салхи ноёлдог бол нийт салхины ангиллаар 39 орчим хувийг 3.6-5.7 м/с хурдтай салхи эзэлдэг байна.

ТЭЗҮ-д тусгагдсан хүчин чадал, техник зэргээр тооцоход ил уурхайн үйл ажиллагаанаас үүсэх PM2.5-ын хоногийн дундаж агууламж хамгийн ихдээ 36 мкг/м3 буюу стандартад заасан хүлцэх агууламжаас 1.5 мкг/м3-ээр бага байх боломжтой бол овоолгоос үүсэх PM2.5-ын хоногийн дундаж агууламж хамгийн ихдээ 0.13 мкг/м3 хүртэл орчны агаарын бохирдлыг нэмэгдүүлэх буюу маш бага үзүүлэлттэй байна. Хүдрийн агуулахаас үүсэх PM2.5-ын хоногийн дундаж агууламж хамгийн ихдээ 5 мкг/м3 буюу MNS 4585:2025 стандартад заасан хүлцэх агууламжаас 7.5 дахин бага байна. Технологийн замаас үүсэх PM2.5-ын хоногийн дундаж агууламж хамгийн ихдээ 83 мкг/м3 буюу MNS 4585:2025 стандартад заасан хүлцэх агууламжаас 2.2 дахин их хэмжээгээр орчны тоосонцрын агууламжийг нэмэгдүүлж болзошгүй юм. Технологийн замаас үүсэх тоосонцор нь гадаргын өндөршил, хэвгий болон салхины зонхилох чиглэлийн дагуу 200 м зайд стандартад заасан хүлцэх агууламжид хүртэл буурч байгаа бол уурхайн эх үүсвэрээс ялгарах тоосонцрын жижиг хэсгүүд 2600 м орчим хүртэлх орон зайд тархахаар байна. Иймд төслийн үргэлжлэх хугацаа богино, дулааны улиралд хэрэгжих тул технологийн замын арчилгаа, усалгаа төлөвлөлтөд нарийвчлан тусгаж ажиллах шаардлагатай.


Зураг 2. Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй PM2.5-ын хоногийн дундаж агууламж, тархалт



Зураг 3. Овоолгоос үүсэх PM2.5-ын хоногийн дундаж агууламж, тархалт



Зураг 4. Овоолгоос үүсэх PM2.5-ын хоногийн дундаж агууламж, тархалт



2.6. УСАН ОРЧИН

Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэр нь ус зүйн мужлалаар Төв азийн гадагш урсалцгүй ай сав мужид хамаарах ба Монгол орны усны сав газрын ангиллаар Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт хамаарч байна. Тус сав газар нь 8 аймаг, 59 сумыг хамарсан нийт 180404.2 км² талбайтай, далайн төвшнөөс дээш дунджаар 1267 м, баруунаас зүүн хүртэл 858 км ба хойноос урагш 424 км бөгөөд нийт хилийн цэсийн урт нь 2700 км бүхий говь, хээрийн бүсүүдийг хамарсан өргөн уудам тал нутаг юм. Монгол орны 29 усны сав газрын хувьд талбайн хэмжээгээрээ 2 дугаарт ордог. Төсөл хэрэгжүүлж буй Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг 100% хамрагддаг.

Тус сав газар нь гадаргын усны сүлжээ муу хөгжсөн дундаж урсцын модуль хойд хэсгээрээ 1л/с км² хүрэх ба сав газрын ихэнх хэсгээр 0.6л/с км², түүнээс бага байдаг бөгөөд усны нөөцийн ангиллаар газрын доорх усны нөөцтэй ангилалд хамаардаг.

Уурхайн ажилчдын унд ахуйн хэрэглээ, ил уурхайн зам усалгаа болон ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд гидрогеологийн хайгуулаар тогтоогдсон төслийн талбайд ойр байрлах гүний худгийн усаас сонгоно.

2.7. ХӨРСӨН БҮРХЭВЧ


Дорноговь аймгийн Алтанширээ сумын “Тойром” нэртэй тусгай зөвшөөрлийн талбайд орших “ВУС” ХХК-ийн Зүүн чандмань толгой өнгөлгөөний чулууны ордын тусгай зөвшөөрөл бүхий нутагт явуулсан судалгааны хүрээнд нийт 4 цэгээс авсан хөрсний дээжүүдийн морфологи, физик-химийн болон механик бүрэлдэхүүний шинжилгээний үр дүнг нэгтгэн дүгнэхэд тухайн нутаг дэвсгэрийн хөрс нь байгалийн нөхцөл, газрын гадаргын хэлбэршил, эх чулуулгийн шинж чанараас ихээхэн хамааралтайгаар элсэрхэг, элсэнцэр механик бүрэлдэхүүн давамгайлсан, хайрга, сайр чулуун хучаас ихтэй, үржил шимийн түвшин сул хөрсөнд хамаарч байна.

Хөрсний гадаргын морфологи шинж чанараар авч үзвэл бүх дээжийн талбай нь далайн түвшнээс дээш 958–1115 м өндөрт байрлах, дов толгойтой, хөндий хоорондын хэлбэршилтэй, жижиг чулуурхаг гадаргатай бөгөөд ургамлын үндэсний тархалт нийтлэг сул, зарим цэгт маш бага байна. Хөрсний өнгө бороос цайвар шар, зэгэл саарал хүртэл хэлбэлзэж, өнгөний шилжилт ихэнхдээ алгуур, зарим цэгт огцом илэрч байна.

Физик-химийн шинж чанарын хувьд бүх дээжид урвалын орчин сул шүлтлэг, ялзмагийн агууламж багаас дунд түвшинд хэлбэлзэж байгаа нь хөрсний үржил шим харьцангуй сул байгааг илтгэнэ. Хөрсөн дэх давсжилтын хэмжээ гүн рүүгээ ихсэх хандлагатай бөгөөд шингээх бүрдэлд натри (Na) агуулж байгаа нь цаашид газрын ашиглалт, ялангуяа ургамалжуулалт, нөхөн сэргээлтийн үед анхаарах хүчин зүйл болно.

Шим тэжээлийн элементүүдийн хувьд хөдөлгөөнт фосфор, кали нь ихэнх дээжид бага эсвэл дунд зэргийн агууламжтай, зарим цэгт бага түвшинд илэрсэн нь ургамал ургах таатай нөхцөл бүрдээгүйг харуулж байна. Хөрсний механик бүрэлдэхүүний задлан шинжилгээгээр физик шаврын эзлэх хувь 10.5–12.2% байгаа нь элсэнцэр болон элсэрхэг шавранцар хөрс давамгайлж, элсний эзлэх хувь өндөр, ялангуяа 2–0.05 мм хэмжээтэй ширхэг зонхилж байгааг тогтоов.

Зураг 5. Төсөл хэрэгжих талбай орчмын хөрсөн бүрхэвчийн хэв шинж



2.8. ХӨРСНИЙ ХИМИ, ФИЗИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Дорноговь аймгийн Алтанширээ сумын зааг нутагт орших MV-021729 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Залаа толгойн хайлуур жоншны ордын лицензийн талбай орчмын хөрсний төлөв байдлыг тодруулж үнэлгээ өгөх зорилгоор хээрийн судалгаа хийсэн. Үүнд: Хөрсний гадаргын төлөв байдал, хөрсний үе давхаргын морфологи шинж чанар, хөрсөнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулж, хөрсний химийн болон физик шинж чанарын төлөв байдлыг тодорхойлох зорилгоор 2025 оны 11 дугаар сарын 22-ны өдөр хөрсний өнгөн давхаргаас 20 см гүн хүртэл 4 цэгээс дээж авсан болно.

Хүснэгт 5. Хөрсний химийн үндсэн шинжийн үзүүлэлтүүд

Дээж №	Гүн, см	pH	CaCO ₃ , %	Ялзмаг, %	ЦДЧ, ds/m	Шим тэжээлийн элементүүд мг/100г	
						P2O5	K2O
1	0-20 см	7.89	0.58	2.040	0.165	2.11	23.6
2	0-20 см	8.00	0.00	2.330	0.087	2.06	24.5
3	0-20 см	8.67	0.45	0.393	0.071	0.11	5.9
4	0-20 см	8.75	0.40	0.389	0.069	0.10	5.8

Хөрсний ус-физик шинж чанарууд ерөнхийдөө хөрсний механик бүрэлдэхүүнээс ихээхэн хамааралтай байдаг бөгөөд механик бүрэлдэхүүн нь 2мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракци нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг. Элсэнцэр болон элсэн механик бүрэлдэхүүнтэй хөрс нь ус чийг тогтоон барих чадвар муутай, ургамалд хялбар ашиглагдах үржил шимээр ядмаг байдаг байдаг ч ургамалын үндэс чөлөөтэй ургаж хөгжих боломжоор илүү байдаг. Судалгааны үр дүнгээс харахад зонхилон тархсан хөрсний ширхэгийн бүрэлдэхүүнд том хэмжээтэй элс болон тоосон фракц давамгайлсан элсэнцэр бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 6. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээж №	Гүн, см	Механик ширхгүүд, ширхгийн хэмжээ %, мм		
		Элс /2-0,05 мм/	Тоос /0.05-0.002мм/	Шавар /<0.002мм/
1	0-20 см	55.6	32.2	12.2
2	0-20 см	63.6	25.9	10.5
3	0-20 см	76.2	14.6	9.2
4	0-20 см	60.1	24.9	15

2.9. УРГАМЛАН НӨМРӨГ

Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт “ВУС” ХХК-ийн олборлолт явуулах лицензийн талбай нь байгалийн бүс бүслүүрийн хувьд цөлөрхөг хээрийн бүсэд ургамал газар зүйн мужлалтаар евроазийн хээрийн мужийн хойт говийн цөлөрхөг хээрийн бүсийн Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтана. Энэ бүсэд өдлөг хялгана-боролзойт, өдлөг хялганат, өдлөг-хялгана-таана-бударганат, өдлөг хялгана-бударганат, харгана-өдлөг хялганат, тэсэг-өдлөг хялганат, хотирөдлөг хялганат, шаваг-өдлөг хялганат, бор бударганат, бор бударгана-хойргот, баглуур болон сөөгт цөлөрхөг хээр их тохиолдоно. Цөлөрхөг хээрт жижиг үетнүүдээс гадна гурвалсан боролзой, төлөгчдүү боролзой, таана, орог тэсэг, бор бударгана, навчгүй баглуур нохой шээрэнгэ, улаан харгана, бунгийн харгана, шивүүрт харгана, нарийн навчит цахилдаг, говийн тост, хамхуул, хамхаг, цульхир, монгол зорлог, монгол догор, данхар хависхана, шарилж, шаваг элбэг ургана.


Зураг 6. Монгол орны ургамал-газар зүйн мужлал



Уг талбайд ургамлын нөмрөгийн мониторинг хийх зорилгоор хээрийн судалгааг явуулах ургамалжлын хувьд 1 м² талбайд мөн 3-5 зүйлтэй, /1м² талбай дахь зүйлийн тоог геоботаникийн бичиглэлийн аргаар, ургацыг жингийн аргаар, мөн газрын хөрсөн дээрх болон, үндэстэй биомассыг жингийн аргаар тодорхойллоо./ Энд монгол өвст, монгол өвс-хазаар өвст цөлөрхөг хээр голлосон Монгол хазаар өвс-таана-хялганат, хазаар өвс-боролз-хялганат бүлгэмдэл бөгөөд энд нийт 4 овог, 8 төрөл, 14 зүйл ургамал бүртгэв.

Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд ургамлын тархалт сийрэг, хөнхор хотгор газар, өндөрлөгүүдийн бэл, хажуу нам толгодоор өвслөг ургамал жигд биш ургасан. Ургамлын нөмрөгийг бүрдүүлэгч гол нэр төрлийн өвс ургамал нь улаан бударгана, бор бударгана, монгол өвс, цагаан өвс, хялгана, хазаар өвс, агь, таана, хөмүүл, зангуу, божмог, шарилж зэрэг болно. Нам дор газраар алтан харгана, хар харгана, дэрс, буйлс ургадаг. Нутаг дэвсгэрийн хэмжээнд модлог ургамал байхгүй. Нэн ховор, ховор ургамал байхгүй.

Зураг 7. Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчмын ургамлан бүрхэвчийн бүлгэмдэл



Хүснэгт 7. Ургамлын бүлгэмдэл

№	Ургамлын хэв шинж	Бэлчээрийн талбай. га	Ургамлын бүрхэц %	Олшрогч ургамлын бүрхэц %	Доройтлын зэрэг
1.	Хазаар өвс-таана-хялганат, хазаар өвс-боролз-хялганат бүлгэмдэл	13.19	25		Дунд
2.	Хазаар өвс, хялгана, алтан харгана оролцсон хялгана-боролзот, хялгана-шарилжит	31.1	19		Хүчтэй

Цав толгод, тал хөндий, нам хотос дагуу тархсан ургамалжилтын 10 хэвшил, бэлчээрийн 8 төрөл ялгарах бөгөөд таана-монгол өвстэй харганат бэлчээр талбай орчимд хамгийн их талбайд тархсан байсан бөгөөд сумын төв рүү ойртох тусам талхлагдан монгол өвс-цахилдагт сийрэг, ургамалтай харганат бэлчээр болон хувирч байна. Энэ нь Алтанширээ орчимд бэлчээрийн даац 2 дахин хэтэрсэнтэй холбоотой байна. Энэ бүс нутагт харгана бүхий хазаар өвс, агь, таана, алтан харгана, ерхөг, бут, шар шаваг, морин шарилж, хонгор зул, хүж өвс, хэрээн нүд, гоёо зээргэнэ, хавислгана, загасгал, багалуур, тогторгоно, бударгана, тэсэг, хамхаг, өмхий өвс, өргөст ортууз, банздоо, оготоньн сүүл, цагаан лооль, цулхир, дэрс, зангуу, тэмээн таваг, тэмээн хөхөл /жимс/ цахилдаг, зэл зангуу, хөмүүл, таана, лууль, алтан гагнуур, алтан ус утас, сухай, буйлс, хайлаас, заг зэрэг төрөл зүйлийн ургамал ургадаг.

Уулын хаяа бэл, налуу тал газар элсэрхүү шавранцар сайргархуу чулуурхаг, давсархаг нимгэн, цөлийн хээрийн бор хөрсөнд хагас ширэгжсэн, зоо манхан элсний заримдаг заримдаг сөөгөнцөрт цөлийн хээрийн бэлчээр зонхилно. Хялганахазаар өвс-тэсэгт (20%) хотгорын чулуурхаг хялгана-бударганат бүлгэмдэл тархана.


2.10. АМЬТНЫ АЙМАГ

Судалгааны талбай Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутгаас Зүүн зүгт 20 км зайд байрлах Залаат толгойн жоншны ордны талбайд амьтны аймгийн судалгааг явуулав (2026.03.28).

Дорноговь аймгийн газар нутаг нь Монгол орны Хөхтөн амьтны тархац нутгийн хувьд Дорнод говийн мужид хамаарна.

- | | |
|---------------------------|--------------------------------|
| 1. Хөвсгөл орчмын тойрог | 6. Баруун хойд Монголын тойрог |
| 2. Хэнтийн тойрог | 7. Хойд говийн тойрог |
| 3. Баруун Хянганы тойрог | 8. Говь-Алтайн тойрог |
| 4. Монгол Дагуурын тойрог | 9. Алтайн өвөр говийн тойрог |
| 5. Хангайн тойрог | |

Зураг 8. Монгол орны зоогеографийн мужлал (А.Г.Банниковынхоор)



“ВУС” ХХК-ний Алтанширээ сумын орчмын хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ судалсан судлаачдын баг 34 зүйл хөхтөн, 8 зүйл шувуу, 2 зүйл 2 нутагтан, 3 зүйл мөлхөгчид байна гэж гаргажээ. Энэ орчимд байсан хар сүүлт, устаж өөр газарлуу нүүсэн цагаан зээрын тархац маш хумигдсан, саарал чоно, шар үнэг, хярс, ховордож байна гэж тэмдэглэгдсэн байна.

Хэвлэлийн мэдээгээр 2019 оны БОННУ-ний тайланд амьтны аймгийн судалгааны дүнд нийт 50 зүйл бүртгэгдсэн ба үүнээс Монголын Улаан номонд 8 зүйл, CITES 5 зүйл, ЗГ-ын 164-р тогтоол 5 зүйл тус бүр бүртгэгджээ (С. Бадамжаргал, Н. Цэгмид нар 2019). 2025 оны судалгаагаар 62 зүйл амьтан тэмдэглэснээс 8 зүйл шувуу, 4 зүйлийн хөхтөн, 3 зүйл мөлхөгч, 16 зүйлийн шавж бүртгэсэн (Error! Reference source not found.8).

Хүснэгт 8. Амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүн (2019, 2025 оны судалгаа)

№	Амьтны зүйлийн нэр		Хэвлэлийн мэдээгээр				Бидний судалгаагаар 2025 он
	Латин	Монгол	2019 он	Монголын Улаан ном	CITES	Бүс нутгийн үнэлгээ	
Хөхтний анги-Mammalia							
Шавж идэштний баг							
1.	<i>Hemiechinus auritus</i>	Дэлдэн зараа	+				
Chiroptera-Гар далавчтаны баг							
2.	<i>Myotis mystacinus</i>	Сахалт багваахай	+				
Rodenta-Мэргчийн баг							
3.	<i>Meriones unguiculatus</i>	Монгол чичүүл	+				
4.	<i>Allactaga bullata</i>	Говийн алагдаахай	+				
5.	<i>Salpingotus kozlovi</i>	Өөхөнсүүлт атигдаахай	+				
6.	<i>Salpingotus crassicauda</i>	Коздовын атигдаахай	+				
7.	<i>Meriones meridianus</i>	Шар чичүүл	+				
8.	<i>Cricetulus migratorius</i>	Бор чичүүл	+				+
9.	<i>Phodopus roborovskii</i>	Элсний чичүүл	+				
10.	<i>Allactaga sibirica</i>	Сибирь алагдаага	+				+
11.	<i>Cardiocranius paradoxus</i>	Таван хуруут атигдаахай	+				
12.	<i>Euchoreutes naso</i>	Соотон алагдаахай	+				
13.	<i>Mus musculus</i>	Гэрийн хулгана	+				
Lagomorpha-Туулайтан баг							
14.	<i>Lepus toloi</i>	Бор туулай					+
Artiodactyla-Туруутны баг							
15.	<i>Gazella subgutturosa</i>	Хар сүүлт	+				
16.	<i>Equus hemionus</i>	Хулан		+	+	+	
17.	<i>Ovis ammon</i>	Аргаль		+			

ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЛТАНШИРЭЭ СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ “ЗАЛАА ТОЛГОЙ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ


18.	<i>Capra sibirica</i>	Янгир		+				
19.	<i>Procapra gutturosa</i>	Цагаан зээр		+			+	+
Carnivora-Мах идэштний баг								
20.	<i>Canis lupus</i>	Саарал чоно		+				
21.	<i>Lynx lynx</i>	Говийн чичүүл		+				
22.	<i>Vulpes vulpes</i>	Шар үнэг		+				
23.	<i>Vulpes corsac</i>	Хярс		+				+
24.	<i>Mustela eversmanni</i>	Өмхий хүрэн		+				
25.	<i>Otocolobus manul</i>	Манул		+				
Aves- Шувууны анги								
Passeriformes-Бор шувууны баг								
26.	<i>Passer ammodendri stoliczkae</i>	Загийн бор шувуу		+				
27.	<i>Eremophilla alpestris</i>	Шоорон эвэрт болжмор		+				+
28.	<i>Corvus corone</i>	Хар хэрээ		+				+
29.	<i>Corvus corax</i>	Хон хэрээ		+				+
30.	<i>Melanocorypha mongolica</i>	Монгол болжмор		+				+
31.	<i>Podoces hendersoni</i>	Хулан жороо		+				
Columbiformes-Тагтаа хэлбэртний баг								
32.	<i>Syrhaptes paradoxus</i>	Ногтруу		+				+
33.	<i>Oenanthe deserti</i>	Цөлийн чогчиго		+				+
34.		Хахилаг		+				
Charadriiformes-Хиазтан баг								
35.	<i>Gallinago gallinago</i>	Шөвгөн хараалж		+				
Falconiformes-Шонхор хэлбэртний баг								
36.	<i>Aegyptius monachus</i>	Хар тас		+	+			+
37.	<i>Buteo hemilasius</i>	Шилийн сар		+				+
38.	<i>Falco cherrug</i>	Идлэг шонхор		+	+	+	+	+
39.	<i>Falco amurensis</i>	Амарын шонхор		+	+	+	+	
40.	<i>Falco naumanni</i>	Зээрд шонхор		+	+	+	+	
41.	<i>Falco tinnunculus</i>	Начин шонхор		+	+	+	+	
Gruiformes-Тогоруу хэлбэртний баг								
42.	<i>Anthropoides virgo</i>	Өвөг тогоруу		+				
Reptilia-Мөлхөгчдийн анги								
Sauria-Гүрвэлийн салбар баг								
43.	<i>Eremias argus</i>	Монгол гүрвэл		+				
44.	<i>Phrynocephalus versicolor</i>	Цоохор хонин гүрвэл		+				+
45.	<i>Eremias multiceclata</i>	Могой гүрвэл		+				
46.	<i>Eremias przewalskii</i>	Говийн гүрвэл		+				+
47.	<i>Teratoscincus przewalskii</i>	Нохой гүрвэл		+				
Serrentes-Могойн салбар баг								
48.	<i>Glyodes halys</i>	Бамбай хоншоорт могой		+				+
Нийт зүйлийн тоо				45	8			18

Хүснэгтээс харахад 4 багийн 45 зүйлийн хөхтөн, шувуу, мөлхөгчид мөн 16 зүйлийн шавж нийт 64 зүйлийг тэмдэглэсэн.

2.11. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ

“БҮС” ХХК-ийн “Тойром” нэртэй талбайд орших чулууны ордын улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамаардаггүй. Гэвч Монгол улсын хилийн зурвас газар байрладаг. Хамгийн ойр тусгай хамгаалалттай нутаг 145-км-т алслагдсан байдаг тул тусгай хамгаалалттай газар нутагт тус төсөл нөлөөлөлгүй гэж үзлээ. Байгалийн аялал жуулчлал “Их нарт” байгалийн нөөц газар Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан сумын заагт орших бөгөөд байгаль, түүхийн дурсгалт зүйлс ихтэй үзэсгэлэнт газар юм. Их Нартын хад нь говийн аргалийн байршил нутгийн хамгийн зүүн хойд хил бөгөөд тухайн газар нутгийг хамгаалах шаардлагатай тул УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор хамгаалалтад авсан.

Зураг 9. Төслийн талбайн ойр байрлах улсын тусгай хамгаалалттай газар



Талбайн хэмжээ нь 66,592 га. Тал, хээр, говийн бүс хосолсон энэ нутагт ховор амьтан, ургамал ихтэй. Их Нартын чулуунд “Хульхан ам”, “Шинэ усны ам”, “Хөх усны ам”, “Элсний ам”, “Гурван хоногийн ам” зэрэг 1-3 км үргэлжилсэн булаг, модтой үзэсгэлэнт газрууд байхаас гадна жанжин Чойрын Их Нартын туурь зэрэг түүх, соёлын дурсгалт газрууд их байдаг. Байгалийн мужлалаар говийн бүсэд багтдаг боловч нутгийн баруун хойт хэсэг нь хээр талын бүсэд хамаарна. Говь хээр хосолсон энэ нутагт таана, хөмүүл, хайлас, цагаан бургас, алтан харгана, лидэр, алтан үндэс, монгол буйлс, морин зээргэнэ, цайны бут, зээрийн ундаа, чихэр өвс, мангир зэрэг 120 гаруй нэр төрлийн эмийн болон эмийн бус ургамал ургадаг ба эмэнд ордог 10 гаруй төрлийн чулуу бий. 26 Амьтдаас аргаль, янгир, чоно, үнэг, хярс, мануул, шилүүс зэрэг туруутан, туулай, зурам, тарвага, сортон алагдаахай байхаас гадна бүргэд, ногтруу, цэн тогоруу, хоёр төрлийн шонхор, ятуу, шар шувуу, ууль, хараацай, тас болон усны шувууд төрөл бүрээрээ байршин амьдардаг. Мөн энд Халзан-уулын рашаан зэрэг янз бүрийн өвчинг анагаах чадалтай рашаан усны нөөц ихтэйгээс гадна барагшун элбэг байна. Ашигт малтмалаас төрөл бүрийн будгийн шороо, зос, нүүрс, жонш болон уран, өнгөт металлын ихээхэн баялагтай. Энэ нөөц газрыг АНУ-ын Денверийн их сургууль, ШУА-ийн Биологийн хүрээлэн болон бусад ТББ-ууд хамтран судалж хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсээр байна. Их Нартын хад нь говийн аргалийн байршил нутгийн хамгийн хойд цэг бөгөөд энэ орчмын газар нутгийг хамгаалалтад авснаар аргалийн тархац нутаг өргөжин тэлэх, бусад ан амьтан өсч үржих болон өвөрмөц тогтоц, унаган төрхийг хамгаалж байна.

2.12. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ бүлэгт “ВУС” ХХК-ийн Залаа толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслөөс төсөл хэрэгжих бүс нутгийн нийгэм, эдийн засаг, ард иргэдэд үзүүлэх шууд болон шууд бус нөлөөллийн үнэлгээг тусгалаа.

“ВУС” ХХК-ийн Залаа толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслөөс Дорноговь аймгийн Алтанширээ сумын нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 9. Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн	Төслөөс учирч болзошгүй нөлөөлөл	
	Эерэг нөлөөлөл	Сөрөг нөлөөлөл
Нутгийн иргэдэд үзүүлж болзошгүй нөлөөлөл		
Ажил эрхлэлт, амьжиргаа	•	
Шилжилт хөдөлгөөн	•	•
Нүүлгэн шилжүүлэлт		•
Эдийн засгийн хөгжилд гарч болох нөлөөлөл		
Дорноговь аймаг	•	
Алтанширээ сум	•	

Нийгэм эдийн засагт учирч болзошгүй нөлөөллийг урьдчилан тооцоход эдийн засаг, дэд бүтцийн салбарт эерэг өөрчлөлт, харин нутгийн иргэд, соёлын өвд эерэг, сөрөг нөлөөлөл аль аль нь гарч болзошгүй боловч нэгдсэн дүнгийн хувьд төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл их байна.

Гэхдээ уурхай ашиглалтын явцад орон нутгийн иргэдтэй үл ойлголцох байдал гарах, уурхай хаагдсаны дараах эдийн засгийн тогтворгүй байдал үүсэх зэргээр сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна.

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. ТӨСЛӨӨС ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

- Ил уурхай, овоолго, зам, бусад байгууламжуудаар газрын гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх;
- Ил уурхай, овоолго, ангилан бутлах цех зэргийг байгуулахад газрын хэвлийг эвдэх
- Уурхайн хаягдал чулуулгийн овоолгоос геологи орчин, агаар, ус бохирдох
- Газрын хэвлийд үүсэх хоосон орон зай нь мал амьтанд аюултай байдал үүсэх
- Гадаад дотоод тээвэрлэлт хийх автозам
- Бутлах цех ажиллах, уурхайн суурингийн объектууд, бусад агуулах зэрэгт өртөх эдэлбэр газар ашиглалтаас хасагдах

